

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Ариунаа
Утас: 93032714

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	10
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	10
3.5.3 Авлага.....	10
3.5.4 Урьдчилгаа.....	11
3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	11
3.5.6 БАРАА МАТЕРИАЛ.....	11
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.8 Өр төлбөр.....	12
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	12
3.5.10 Орлогын данс.....	13
3.5.11 Зардлын данс.....	13
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	14
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	16
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	17
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	17
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

додд. 04.22 № 416

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хэнтий аймгийн Батширээт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн орлогын 49.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, тооцоо нийлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлээгүй нь тохиолдсон байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, хэмжилт гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

023030687

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,366,940.2	1,569,286.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	783,688.1	928,045.3
33	АВЛАГА	252,135.9	356,411.6
34	УРЬДЧИЛГАА	-	11,038.8
35	БАРАА МАТЕРИАЛ	317,616.2	263,804.6
36	НӨӨЦИЙН БАРАА	13,500.0	9,986.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,962,767.8	5,323,652.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,962,767.8	5,323,652.5
392	Биет хөрөнгө	4,714,549.5	5,076,304.5
393	Биет бус хөрөнгө	248,218.3	247,348.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,329,708.0	6,892,938.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,720.8	33,294.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,720.8	33,294.2
413	Өглөг	1,720.8	33,294.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,327,987.2	6,859,644.7
51	Засгийн газрын хувь оролцоо	6,327,987.2	6,859,644.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,505,555.0	1,502,028.1
512	Хуримтлагдсан үр дүн	3,852,963.9	4,388,148.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	969,468.2	969,468.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,329,708.0	6,892,938.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,729,593.4	5,168,441.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	991,800.7	750,079.9
110	Орлогын албан татвар	60,681.9	127,170.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	60,681.9	127,170.2
113	Хөрөнгийн албан татвар	3,300.0	54,228.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	927,818.9	568,681.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	877,880.9	725,948.8
120	Нийтлэг татварын бус орлого	877,880.9	725,948.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,859,911.8	3,692,412.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,469,734.5	4,595,867.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,469,734.5	4,595,867.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,089,203.7	2,729,822.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,196,701.7	1,342,300.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,211.5	178,384.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,487.1	198,497.2
2104	Хангамж, бараа материалын зардал	58,946.9	85,870.2
2105	Нормативт зардал	72,110.2	172,449.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,523.8	99,798.4
2107	Томилголт, зочны зардал	10,640.5	15,473.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,553.2	162,038.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	382,028.9	475,010.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,380,530.8	1,866,045.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,259,858.9	572,573.6
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	3,456.9
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	34,150.5
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,259,858.9	541,880.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,029,958.3	4,540,362.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	991,800.7	750,079.9
110	Орлогын албан татвар	60,681.9	127,170.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	60,681.9	127,170.2
113	Хөрөнгийн албан татвар	3,300.0	54,228.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	927,818.9	568,681.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,208.7	12,202.7
1181	Газрын төлбөр	1,899.5	3,270.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	913,710.7	553,208.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	162,640.7	183,883.9
120	Нийтлэг татварын бус орлого	162,640.7	183,883.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,875,516.9	3,606,398.1
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,229,759.3	4,079,671.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,229,759.3	4,079,671.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,844,170.8	2,218,222.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,218,463.2	1,351,351.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	165,072.6	181,820.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,987.2	159,322.9
2104	Хангамж, бараа материалын зардал	128,603.6	81,186.9
2105	Нормативт зардал	52,702.9	120,806.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,046.8	107,797.9
2107	Томилолт, зочны зардал	10,640.5	15,473.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,737.5	88,573.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,916.6	111,889.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,385,588.5	1,861,448.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	800,199.0	460,691.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	91,110.8	210,333.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	91,110.8	210,333.8
2200	Дотоод эх үүсвэрээр	91,110.8	210,333.8
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(91,110.8)	(210,333.8)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	45,000.0	106,000.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(45,000.0)	(106,000.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	664,088.2	144,357.2
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	119,599.9	783,688.1
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	783,688.1	928,045.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,555.0	969,468.2	2,593,105.0	-	5,068,128.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,555.0	969,468.2	2,593,105.0	-	5,068,128.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт					
8	Зарласан ногдол ашиг					
9	Тайлант үеийн үр дүн	-	-	1,259,858.9	-	1,259,858.9
10	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,555.0	969,468.2	3,852,963.9	-	6,327,987.2
11	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,555.0	969,468.2	3,852,963.9	-	6,327,987.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(6,695.6)	-	(6,695.6)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,555.0	969,468.2	3,846,268.3	-	6,321,291.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт					
18	Зарласан ногдол ашиг					
19	Тайлант үеийн үр дүн	-	-	541,880.0	-	541,880.0
20	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,502,028.1	969,468.2	4,388,148.3	-	6,859,644.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,959,331.0	2,425,459.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,341,104.0	2,198,267.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,284,263.3	2,149,695.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,343,994.8	1,323,564.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,123.6	176,932.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,774.8	159,222.9
2104	Хангамж, бараа материалын зардал	75,250.8	73,494.3
2105	Нормативт зардал	79,322.1	72,693.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,507.9	192,837.3
2107	Томилолт, зочны зардал	14,933.3	14,185.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,503.4	56,697.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,852.6	80,068.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,840.7	48,571.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,840.7	48,571.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	433,227.0	121,192.1
2200	Дотоод эх үүсвэрээр	433,227.0	121,192.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	185,000.0	106,000.0
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,959,331.0	2,522,761.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,205,382.1	1,186,049.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,497,750.3	1,204,137.2
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,512.5	23,545.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	114,943.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	212,246.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	149,200.0	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	149,200.0	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,802.9	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,910.9	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,312.5	
2104	Хангамж, бараа материалын зардал	2,404.6	
2105	Нормативт зардал	48,113.4	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,902.4	
2107	Томилголт, зочны зардал	1,287.5	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,051.2	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,820.4	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,397.0	
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,410.9	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,986.1	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	149,200.0	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,200.0	

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Г.Гансүх танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн орон нутгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 61 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Батширээт сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөгүй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөгүй байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Батширээт сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн үйлчилгээнд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлснээр иргэдэд чиглэсэн иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг бий болгож, иргэдийнхээ аюулгүй амьдрах орчныг тантай хамт хэрэгжүүлж, тамгатай нутгаа хөгжүүлнэ.” гэж тодорхойлсон байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 3,469.7 сая төгрөгийн 1 хувиар буюу 34.7 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 26.0 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 783.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 928.0 сая төгрөг болж, 144.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	781.3	925.7	144.4	99.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	2.3	2.3	-	0.2
Хадгаламж				
Дүн	783.6	928.0	144.4	100%

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 895.0 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 30.7 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна. Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн төвийн 0.1 сая төгрөг, тусгай сангуудын 212.2 сая төгрөг, сумын орлогын ерөнхий дансны 682.7 сая төгрөг, арилжааны банкны үлдэгдэлд Батширээт ойн анги, хот тохижилтын 30.7 сая төгрөг байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 2.3 сая төгрөг байгаа нь оны эцэст орсон хөрөнгийн орлого, малд ногдох албан татвар, ойн нөөц ашигласны төлбөр, газрын төлбөртэй холбоотой мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт данс үлдэгдэлгүй байна.

3.5.3 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 252.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 356.4 сая төгрөг болж, 104.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага		0.1	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага		92.5	92.5
Бусад авлага	8.0	11.5	3.5
Зээлийн авлага	244.1	252.3	8.2
Дүн	252.1	356.4	104.3

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад авлага дансанд Засаг даргын тамгын газрын зураг төсвийн 10.0 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний 92.5 сая төгрөг, Соёлын төвийн 1.5 сая төгрөг нийт 104.0 сая төгрөгийн авлага байна.

Зээлийн авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих санаас олгосон 0-1 жилийн 106.2 сая төгрөг, 1-2 жилийн насжилттай 20.0 сая төгрөг, 2-3 жилийн насжилттай 67.6 сая төгрөг, 3-4 жилийн насжилттай 58.5 сая төгрөгийн зээлийн авлага байна.

Аудитын илрүүлэлт: Авлагын данстай холбоотой 10.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Засаг даргын тамгын газар тайлант онд нутгийн удирдлагын ордны зураг төсвийн үнийг урьдчилан шилжүүлсэн 10.0 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсныг аудитын явцад залруулж авлага үүсгэсэн.

Цэцэрлэг нь 0.4 сая төгрөгийн авлага, өглөгийг үндэслэлгүй хаасан зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 11.0 сая төгрөг болж, 11.0 сая төгрөгөөр өссөн байна. Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал		11.0	11.0
Дүн	-	11.0	-

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэл ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлөөс үүссэн авлага байна.

Аудитын илрүүлэлт: Урьдчилгаа данстай холбоотой 11.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Засаг даргын тамгын газар сумын төвийн хаягжуулалтын ажил гүйцэтгүүлэхээр гүйцэтгээгчид урьдчилан шилжүүлсэн 11.0 сая төгрөгийг зардалд хааж урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй байсныг аудитын явцад урьдчилж гарсан зардлаар бүртгүүлж, үр дүнгийн тайланд залруулсан.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс үлдэгдэлгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 317.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 263.8 сая төгрөг болж, 53.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	79.6	65.4	-14.2
Бэлэн бүтээгдэхүүн	4.8	0.1	-4.7
Хангамжийн материал	223.1	186.8	-36.3
Мал амьтад	10.1	11.5	1.4
Дүн	317.6	263.8	-53.8

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материалын 408.8 сая төгрөгийн орлого авснаас 370.5 сая төгрөгийг худалдан авч, 13.3 сая төгрөгийг хандиваар, 24.5 сая төгрөгийг шилжүүлэн авсан байна

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,962.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,323.6 сая төгрөг болж, 360.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бие хөрөнгө	4,714.5	5,076.3	361.8
Биет бус хөрөнгө	248.2	247.3	(0.9)
Дүн	4,962.7	5,323.6	360.9

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 109.0 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 66.2 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 453.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 5.8 сая төгрөг, акталсан 66.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данстай холбоотой 5.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

Батширээт сум тохижилт нь байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй зөрчил илэрснийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 33.3 сая төгрөг болж, 31.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0.2	3	2.80	8.86
Бараа үйлчилгээний зардлын өглөг		30.3	30.30	95.89
Татварын өглөг /ТӨҮГ/	0.2		(0.20)	(0.63)
Дансны өглөг /ТӨҮГ/	1.3		(1.30)	(4.11)
Богино хугацаат өр төлбөр дүн	1.7	33.3	31.6	100.0

Эх сурвалж: Батширээт сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3.0 сая төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг, 30.3 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардлын өглөг байна.

Аудитын илрүүлэлт: Өр төлбөр данстай холбоотой 2.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

Цэцэрлэг нь 0.8 сая төгрөгийн ажиллагсдын цалинги шимтгэлийн зардлаас төлсөн зөрчил илэрснийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

Эрүүл мэндийн төв нь байгууллагад төлөх эмийн зардлын 2.0 сая төгрөгийн өглөгийн тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байсан зөрчилд албан шаардлага өгсөн байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,328.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,859.6 сая төгрөг болж, 531.6 сая төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Батширээт сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 17 дугаар тогтоолд зааснаар Батширээт сумын Засаг даргын тайлант онд 320.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 761.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 237.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	22.0	82.7	60.7	375.9
Хөрөнгийн орлого	28.0	39.3	11.3	140.4
Хөрөнгө борлуулсаны орлого		4.3	4.3	
Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал	0.3	0.8	0.5	266.6
Бууны албан татвар	3.3	3.2	-0.1	97.2
Малд ногдох албан татвар	0.0	51.0	51.0	
Улсын тэмдэгтийн хураамж	3.5	4.1	0.6	115.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.9	1.2	0.3	133.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6.0	7.0	1.0	115.8
Ойн нөөц ашигласны төлбөр	243.9	550.2	306.3	225.6
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2.0	3.0	1.0	151.7
Газрын төлбөрийн орлого	2.4	3.3	0.9	136.3
Торгуулийн орлого	5.6	9.0	3.4	160.6
Бусад орлого	3.0	2.5	-0.5	83.0
Нийт дүн	320.9	761.6		

Үйл ажиллагааны орлого 60.7 сая төгрөгөөр давсан нь самар худалдан авсан аж ахуйн нэгж байгууллагыг татвар төлөгчөөр бүртгүүлж, орлогын албан татвар төвлөрүүлснээс, ойн нөөц ашигласны төлбөр 306.3 сая төгрөгөөр давсан нь самар худалдан авах тусгай зөвшөөрөлтэй байгууллагаас гэрээний дагуу төлүүлсэн орлогоос шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 227.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн орлогыг 93.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж 320.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,959.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,596.8 сая төгрөгийг урсгал зардалд, 175.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 187.5 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,205.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,357.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 140.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 232.7 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,205.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,408.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Малын тоо толгойн албан татварын 51.0 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3 ажил 175.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, 2 ажлыг хэрэгжүүлж 88.6 сая төгрөг зарцуулжээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 99.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 30.5 сая төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сан, жижиг дунд бизнесийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 9.1 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 1.3 сая төгрөгөөр тасарсан нь Засаг даргын тамгын газар, Батширээт сум дундын ой ангийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,425.5 сая төгрөг буюу 81.9 хувьтай байгаа нь цалин, шимтгэл, тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 19.3 сая төгрөгийг улсын төсөвт, 295.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 122.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 27.0 сая төгрөг, нийт 149.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үндсэн цалин, шимтгэлд 17.2 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 2.4 сая төгрөг, нормативт зардалд 48.1 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1.9 сая төгрөг, томилолтод 1.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 6.1 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 31.8 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 25.4 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 15.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 707.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

Батширээт сум тохижилт шилэн дансны сайтад мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 20.0 сая төгрөг, төсвийн гүйцэтгэл, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй зөрчил илэрснийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Засаг даргын тамгын газар шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 1,193.сая төгрөгийн 117 мэдээллээс 884.6 сая төгрөгийн 103 мэдээллийг мэдээлж, 309.3 сая төгрөгийн 14 мэдээллийг мэдээлээгүй байсан. Зөрчлийг байна. Мэдээллийг 94.2 хувьтай мэдээлсэн байна. Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургууль таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 51.5 сая төгрөг, 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээний 77.3 сая төгрөгийн мэдээллүүдийг байршуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Эрүүл мэндийн төв шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад орлогын 222.5 сая төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 26.9 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан зөрчил илэрсэн. Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 12.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 33.2 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	12.1	1	12.1	1		50%
Зөвлөмж	3	33.2	3	33.2			100%
Нийт	5	45.3	4	45.3	1	0	

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгайн сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан тус сумын харьяа Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын дунд сургууль, Эрүүл мэндийн төв, Батширээт сум дундын ой ангийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Батширээт сум тохижилтын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн. Цэцэрлэгийн санхүүгийн тайланд хувийн аудитын “Өндөрхаан итгэл аудит” компани аудит хийж, “Хязгаарлалттай” дүгнэлт өгссөн байна.

Аудитаар нийт 49.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 49.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, албан шаардлага хэрэгжүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг зөрүүгүй нэгтгэсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

Өмнөх оны аудитаар Хавтгарын хөгжил ОНӨОААН-ийг татан буулгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, аж ахуйн нэгжийг татан буулгах арга хэмжээ аваагүй тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 778.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 22.4 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж,

587.1 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 168.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Орон нутгийн орлогын төвлөрүүлэлттэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн тогтмол зардлын зарцуулаагүй үлдэгдэл 49.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй улсын төсөвт төвлөрүүлсэн.

3.1.2 Эрсдэл:

Орон нутгийн орлогыг буруу төвлөрүүлдэг, орлогын тооцоог хийдэггүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төвлөрүүлэлтийг сумын төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх, оны эцэст орлогын тооцоог улс, орон нутгийн төсвөөр хийж, баталгаажуулж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2022.04.17	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ХЭА-2022/09/НА-СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг дарга		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй	-	Зөвлөмж өгсөн.	Дарга	Ч.Ундармаа
2	Дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй	-	Зөвлөмж өгсөн.	Дарга	Ч.Ундармаа
3	Өмнөх онд өгсөн аудитын албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй	-	Албан шаардлага өгсөн.	Дарга	Ч.Ундармаа
Батширээт сум дундын ойн ангийн алдаа, зөрчлийн дүн					
1	“Батширээт сум тохижилт” ОНӨААТҮГ -ын дарга нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг дүгнүүлээгүй.	-	Зөвлөмж өгсөн.	Дарга	Э.Энхболд
2	Байгууллагын эзэмшилд байгаа 5.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй.	5.9	Албан шаардлага өгсөн.	Дарга	Э.Энхболд
3	Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 20.0 сая төгрөгийн 1, төсвийн гүйцэтгэлийг мэдээлээгүй, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй.	20.0	Зөвлөмж өгсөн.	Дарга	Э.Энхболд
Батширээт сум тохижилтын алдаа зөрлийн дүн		25.9			
1	Цалингийн зардал 0.6 сая төгрөгийг нийгмийн шимтгэлийн даатгалын зардлаас шилжүүлэн төлсөн зөрчил илэрсэн.	0.6	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг М.Мөнхбаяр
2	Сум тохижилтын ОНӨҮГ-т гэрээт ажилд шилжүүлсэн 20.0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	20.0	Зөвлөмж өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг М.Мөнхбаяр

3	Нийт мэдээлбэл зохих 1,193.сая төгрөгийн 117 мэдээллээс 884.6 сая төгрөгийн 103 мэдээллийг мэдээлж, 309.3 сая төгрөгийн 14 мэдээллийг мэдээлээгүй байна. Мэдээллийг 94.2 хувьтай мэдээлсэн байна.	309.3	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг М.Мөнхбаяр
4	Тайлант онд 14.5 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	14.5	Албан шаардлага өгсөн.	Дарга Нягтлан бодогч	Б.Эрдэнэчимэг М.Мөнхбаяр
5	Тайлант онд нутгийн удирдлагын ордны зурагт төсвийн үнийн урьдчилан шилжүүлсэн 10.0 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байна.	10.0	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	М.Мөнхбаяр
6	Сумын төвийн хаягжуулалтын ажил гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгчид урьдчилан шилжүүлсэн 11.0 сая төгрөгийг зардалд хааж, урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй байна.	11.0	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	М.Мөнхбаяр
Засаг даргын тамгын газрын алдаа, зөрчлийн дүн		365.5			
1	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл 51.5 сая төгрөг, 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээ 77.3 сая төгрөгийн мэдээллүүдийг тус тус байршуулаагүй байна.	128.8	Зөвлөмж өгсөн.	Захирал Нягтлан бодогч	Ц.Цогзолмаа Б.Энхтөр
Ерөнхий боловсролын сургуулийн алдаа, зөрчлийн дүн		128.8			
1	Цалингийн зардлаас НДШ төлсөн	0.8	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч Нягтлан бодогч	А.Хандцоо Б.Энхтөр
2	Ажиллагсдын цалинг НДШ-ийн тайланд дутуу мэдүүлсэн.	4.5	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч Нягтлан бодогч	А.Хандцоо Б.Энхтөр
3	Авлага өглөгийг хаасан	0.4	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Б.Энхтөр
Цэцэрлэгийн алдаа, зөрчлийн дүн		5.7			
1	Цалингийн зардлыг үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд 1.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн.	1.0	Залруулга хийсэн.	Нягтлан бодогч	Н.Одончимэг
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын алдаа, зөрчлийн дүн		1.0			
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад орлогын 222.5 сая төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 26.9 сая төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	249.4	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Отгончимэг Э.Ононтунгалаг
2	Байгууллагад төлөх эмийн зардлын 2.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	2.0	Албан шаардлага өгсөн.	Эрхлэгч Нягтлан бодогч	Я.Отгончимэг Э.Ононтунгалаг
Эрүүл мэндийн төвийн алба зөрчлийн дүн		251.4			
1	Орон нутгийн төсвийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн.	49.2	Зөвлөмж өгсөн.	Засаг дарга	Г.Гансүх Г.Энхбат

				Нягтлан бодогч	
2	Хавтгарын хөгжил ОНӨОААН-ыг татан буулгах арга хэмжээ авах албан шаардлага биелүүлээгүй.	-	Хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.	Засаг дарга Нягтлан бодогч	Г.Гансүх Г.Энхбат
Засаг даргын алдаа, зөрчлийн дүн		49.2			
Нийт алдаа зөрчлийн дүн		827.5			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 22

Дугаар 244/А2370448
ХТА 2022/09/НА - СТА-ТШЗ

Чингис хот

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар Хавтгарын хөгжил ОНӨААН-ийг татан буулгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, аж ахуйн нэгжийг татан буулгах арга хэмжээ аваагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д " Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батширээт сумын Хавтгарын хөгжил ОНӨААН-ын захирал Г.Ганцогтод сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Батширээт сумын Засаг дарга Г.Гансүхэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.АРИУНАА

Д.ОЮУНТУЯА

